

## ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2025 оны 05 дүгээр  
сарын 11-ний өдөр

№ 25/11

Сайншанд  
хот

Энэхүү Хамтран ажиллах санамж бичгийг (цаашид “Санамж бичиг” гэх)

Нэг талаас: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж, 12/1, Очир центр, 5 давхар, 505 тоот хаягт байрлах “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд (РД: 8398801, цаашид “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэх), түүнийг төлөөлж, Ерөнхийлөгч Т.Баттулга

Нөгөө талаас: Говьсүмбэр аймгийг төлөөлж, Засаг дарга Т.Бат-Эрдэнэ нар дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү Санамж бичгийн зорилго нь талууд Монгол Улсад аялал жуулчлалын салбарыг бүсчилэн хөгжлүүлэхэд хамтран ажиллах, Говьсүмбэр аймагт аялал жуулчлалын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлд хамтран ажиллах, Говьсүмбэр аймагт аялал жуулчлалаар хүлээн авч буй жуулчдын тоог нэмэгдүүлэх энэ төрлийн үйл ажиллагаанд аймгийн аялал жуулчлалын оролцогчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, идэвхжүүлэхэд оршино.

1.1.Энэхүү Санамж бичгийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн №64 тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрэм холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг тус тус баримтална.

### Хоёр. Хамтын ажиллагааны үндсэн чиглэл

2.1.Талууд санамж бичгийн хүрээнд энэхүү зүйлд заасан үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлнэ.

2.2.Санамж бичгийн хүрээнд Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа:

2.2.1.Говьсүмбэр аймагт аялал жуулчлалын урсгалыг нэмэгдүүлэхэд шаардлагатай төрийн бодлого, тогтоол, шийдвэр зэрэг эрх зүйн баримт бичиг

боловсруулах, батлуулахад Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны хуралд танилцуулах;

2.2.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.5-д заасны дагуу Говьсүмбэр аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа тур оператор, аяллын агентийн бүртгэлийн хөтлөх, хуульд заасан тур операторын гэрчилгээг олгох;

2.2.3. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.6-д заасны дагуу Говьсүмбэр аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа жуулчны үйлчилгээний байгууллага (байр сууц (жуулчны бааз, зочид буудал), тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийн зэрэглэлийг тогтоох;

2.2.4. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.1, 26.1-д заасны дагуу Говьсүмбэр аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийг бүртгэх;

2.2.5. Говьсүмбэр аймагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээлэл болон холбогдох эрх зүйн актын талаар мэдээлэл өгөх, түүний талаар танилцуулгыг хийх;

2.2.6. Аялал жуулчлалын үйл ажиллагаа шаардлагатай төрийн дэмжлэгийг үзүүлэхэд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах;

2.2.7. Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалын судалгаа, дата мэдээллийг хамтран гаргах, Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар өөрийн цахим хуудас, олон нийтийн сүлжээний сувгаар сурталчлах;

2.2.8. Говьсүмбэр аймагт хүний нөөцийг чадавхижуулах, хөгжүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн сургалтыг төрөлжүүлэн хамтран зохион байгуулах;

2.2.9. Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг дэмжин ажиллах.

2.3. Энэхүү санамж бичгийн хүрээнд Говьсүмбэр аймгийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаа:

2.3.1. Өөрийн аймагт аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэх хөгжүүлэх санал, санаачлага, холбогдох судалгааг боловсруулах, сайжруулах, танилцуулах, хэрэгжүүлэх;

2.3.2. Говийн бүсийн брэнд бүтээгдэхүүн, эвент арга хэмжээг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоход хамтран ажиллах;

2.3.3. Аялал жуулчлалын тухай хуулийн 23.1.7-д заасны дагуу Говьсүмбэр аймагт зохион байгуулагддаг аялал жуулчлалын араг хэмжээний товыг өмнөх оны 10-р сарын 01-ний өдрөөс өмнө гарган олон нийтэд болон Нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд мэдээлэх;

2.3.4. Байгаль орчин, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүх нийтийн аялал жуулчлалын боловсрол олгох ажлын хүрээнд хамтран контент бүтээх ;

2.3.5. Аялал жуулчлалын салбарын техникийн зохицуулалт, стандартыг таниулах, хэрэгжүүлэх, шинээр боловсруулагдаж буй техникийн зохицуулалт, стандартууд дээр санал авч хамтран ажиллах;

2.3.6. Монгол Улсыг сурталчлах түлхүүр үг болох "Go Mongolia" "Go Mongolia Always Moving" өөрийн аймагт сурталчлах, хил орчмын болон бусад төрлийн аливаа аялал жуулчлалын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэх, сурталчлах;

2.3.7. Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд үр өгөөжтэй шинэ төсөл хөтөлбөрийг хамтран санаачилж, ерөнхий чиглэл, цар хүрээ, дэвшилтэт санаа, үр дүнгийн талаар санал мэдээлэл солилцох, харилцан тохиролцох;

2.3.8. Аялж буй жуулчдын аюулгүй байдлыг хангах, үүнд тухайн орон нутгийн Цагдаа, Онцгой байдал болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах, тэднийг оролцуулах;

2.3.9. Говьсүмбэр аймгийн аялал жуулчлалын статистик мэдээллийг Аялал жуулчлалын тухай хуулийн 23.1.6-д заасан мэдээллийг сангийн дагуу хөтлөх;

2.3.10. Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүс, аялал жуулчлалын дэд бүтэц, отоглох цэг бий болгоход боломжит дэмжлэгийг үзүүлж ажиллах.

### **Гурав. Ажлын удирдлага зохион байгуулалт, хариуцлага**

3.1. Талууд энэхүү санамж бичгийн 2.2, 2.3-т заасан арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан үйл ажиллагаа, түүний төлөвлөгөө зэргийг энэхүү санамж бичгийн хавсралтаар баталж болно.

3.2. Талууд энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын асуудлыг харилцан зөвшилцөж, хамтран ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулан ажиллана.

3.3. Хамтын ажиллагааны явцад аль нэг талын гишүүнээс гомдол гаргах нь Санамж бичгийг цуцлах, хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй бөгөөд гомдлыг эвийн журмаар зөвшилцөж шийдвэрлэхэд талууд хичээж ажиллана.

3.4. Санамж бичгийн хэрэгжүүлэх явцад талуудын аль нэгэнд хохирол учирсан тохиолдолд талууд тухайн хохирлыг боломжит хугацаанд хамтран барагдуулах (аль нэг талын санаатай буруу үйлдлээс болсон тохиолдолд тухайн буруутай тал) бөгөөд энэ нь санамж бичгийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, эсхүл шууд цуцлах үндэслэл болохгүй.

3.5. Талууд санамж бичигт дурдсан асуудлын хэрэгжилтийн явц, биелэлтийг харилцан мэдээлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллана.

3.6. Талууд Санамж бичгийн тухайн жилийн биелэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан дүгнэнэ.

### Дөрөв. Талуудын холбоо барих хаяг

4.1.Талууд санамж бичигтэй холбоотойгоор харилцахдаа доорх хаяг мэдээллийг үндэслэнэ.

4.1.1.Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн мэдээлэл

a)Утас: 77128822, 99030928

b)Цахим шуудан: [info@mto.mn](mailto:info@mto.mn)

c)Харилцах этгээд: Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал М. Нарангэрэл

4.1.2 Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар

a)Утас: +976 70543434

b)Цахим шуудан: [govisumber.gov.mn](mailto:govisumber.gov.mn)

c)Харилцах этгээд: Говьсүмбэр аймгийн Засаг дарга Т.Бат-Эрдэнэ

4.2.Хэрэв талуудын аль нэг нь энэхүү санамж бичгийн 4.1-т заасан мэдээлэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 14 хоногийн дотор аливаа хэлбэрээр мэдэгдэж баталгаажуулна.

4.3.Санамж бичгийг талууд 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 2028 оны 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 3 (гурван) жилийн хугацаатай байгуулав.

4.4.Энэхүү санамж бичгийн хугацааг талууд харилцан тохиролцон сунгаж болно.

4.5.Талуудын удирдлага өөрчлөгдсөнөөс үл хамааран Санамж бичиг нь үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

4.6.Энэхүү Санамж бичгийг 2025 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн бөгөөд эх хувь тус бүр нэгэн адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН  
ХОЛБООНИЙГИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ЕРӨНХИЙДӨГЧ Т.БАТТУДГА



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Т.БАТ-ЭРДЭНЭ



**Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон Говьсүмбэр аймгийн  
хэрэгжүүлэх тусгайлсан үйл ажиллагаа**

1. “Боржигин наадам” бүсийн эвент
2. “Бүйлс цэцэглэх цаг-Монгол сакура” эвент
3. “Боржигин хаадын харваа” олон улсын эвент
4. Чойрын богд уулын тусгай хамгаалалттай газарт “Боржигин тойром”, Дүйнхэр эргэх ёслол шашин, урлагийн цэнгүүн, шагайн харвааны эвент
5. Монгол улсад зохион байгуулагдах олон улсын үзэсгэлэн, яармаг, эвентүүдэд оролцох. (“Нүүдэлчин Монгол” өв соёлын наадам, ITM аялал жуулчлалын үзэсгэлэн)
6. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын чиглэлийн байгууллагуудад сургалт зохион байгуулах, хөтөч бэлтгэх.